

УЛСЫН ШАЛГАЛТ - 2023

МОНГОЛ ХЭЛ

XII АНГИ

Аймаг/дүүрэг:

Сум:

Сургууль:

Анги: Бүлэг:

Овог:

Нэр:

САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

- Эхийг анхааралтай уншаад, даалгавруудыг гүйцэтгээрэй.
- Шалгалт 80 минутад үргэлжлэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан, бүх даалгаврыг гүйцэтгээрэй.

Далай ээж цаазын тавцан дээр

Хөвсгөл нуурын тухай яриа, домог олон бий. Бүр XVII зуунд мөсөн дээр дээгүүр нь морин хөсгөөр тээвэр хийдэг байхад нуурын дундах Далайн хүйс нэртэй арап дээр олон хэл мэддэг нэгэн эрдэмтэй лам уг ажлыг төвлөрүүлэн атгаж байжээ. Тэр: “Хөвсгөл бол ариун нуур. Өчүүхэн ч бузарлаж болохгүй” хэмээн морины баас хийх тусгай саваянчин жинчин бүрд ганзагалуулдаг байсныг тухайн үед олон хэл дээр гарсан эрдэм шинжилгээний холбогдолтой номд өгүүлжээ.

Сүрлэг их уулсаас эх авсан зуу шахам гол горхи цутгадаг бялхам уст Хөвсгөлөөс Эгийн гол гарч Сэлэнгэ мөрөнд нийлээд улмаар Байгаль нуурт цутгана. Хөвсгөл нуурын сав газраас эхтэй Ариг, Үүрийн гол, Дэлгэр мөрөн болон Хангайн нурууны тунгалаг уст Идэр, Чулуут, Олон голын бэлчирт Сэлэнгэ мөрөнд нийлж дэлхийн цэвэр усны тавны нэгийг агуулдаг Байгальд цутган нийт усных нь 60 хувь болно. Амьтан ургамлынхаа аймгаар Хөвсгөл Байгальтай их төстэй. Хөвсгөлийн хадран, нутагшсан омуль, тул, зэвэг, улаан нүдэн, балиус зэрэг арваад зүйлийн загасны агнуурын нөөц жилд олон мянган тонноор хэмжигдэнэ. Хөвсгөлийн уул тайгад манай улсын ойн нөөцийн 24 хувь бий.

Байгалийн өвөрмөц шинж, гоо үзэсгэлэн бүрдсэн нуурын хамгийн гайхамшиг нь түүний ус юм. Эрдэс, давс, органик бодисгүй, уулын горхиных шиг тунгалаг устай нуурын хэдэн арван метрийн гүн дэх загас, чулуу хүртэл ил харагдах нь үнэхээр гайхалтай. Дэлхийн гадаргын нийт усны хэмжээ 1406 сая шоо дөрвөлжин километртэй тэнцдэг. Түүний өчүүхэн бага хэсэг 123 мянган шоо дөрвөлжин км нь ундааны ус юм.

Хөвсгөл нуур цэвэр усны хэмжээгээр зөвхөн Байгалийн дараа л орох юм. Уулс бий болоход үүссэн гүн хонхор дагаж тогтсон учир усны багтаамж ихтэй, ёроолынх нь талбайн бараг далан хувь зуугаас илүү, зарим газраа 268 метр хүртэл гүнзгий. Монгол орны нийт гол мөрний арван жилийн урсацтай тэнцэх хэмжээний цэвэр цэнгэг усыг Хөвсгөл ай савдаа агуулдаг байна.

Амьд бүхний эх ус билээ. Гэтэл ертөнцийн хүмүүсийн тэн хагас уух усаар гачигдаж, усны нийт нөөц бохирдох төдийгүй бүр хордох аюулд оржээ. Иймээс усны төлөө тэмцэл бол амьдралын төлөө тэмцэл юм. Энэ утгаар нь авч үзвэл Хөвсгөл нуурыг хамгаалах асуудал нэн онцгой юм. Гэтэл бид улс орондоо байтугай дэлхийд ховорхон цэнгэг усны эрдэнийн бумба болсон цор ганцхан Хөвсгөл нуураа, ард түмэндээ хайлрагдсан “Далай ээжээ” хөнөөхөөр цаазын тавцан бэлтгэж байдаг нь юу болж байгаа хэрэг вэ? Хөвсгөлийг дотор, гаднаас нь бид өөрсдөө хайр найргүй бохирдуулж байна. “Далай ээжийн” ариун хэвлэйд хөвж явдаг нефть тээврийн “Ургац” чиргүүл юуны урьд “хор агуулсан” хар хорхой болж байна.

Хөвсгөл нуурыг хамгаалах захиргаанаас нефть тээврлэдэг “Ургац” чиргүүлд үзлэг хийсэн тухай актад шатахуун тээврийн уг чиргүүл онгоц нуурыг бохирдуулах онцгой аюултайг анхааруулжээ. Ёроолыг нь цементээр шавж, олон газар нөхөөс тавьж, хоёр шахуурга нь бүрмөсөн элэгдэж гүйцээд ган хоолойнууд зэвэрч, шахуургын динамаас нь үе үе оч хаяж, цахилгааны утасны тусгаарлагч шалбарч, залгуурын таг, сууринууд хагарч оч гялалзах болжээ. Энд ямар нэг байшин барилга, ердийн машин техник бус 300 тонн нефть агуулдаг чиргүүл онгоцны тухай ярьж байгаа хэрэг.

Шатахууныг ийм чиргүүлээр (баржа) тээврлэхийг ЗХУ-д бүр 60-аад оны үед хатуу хориглосон. Учир нь нефть ачсан “гац” чиргүүлд үзлэг хийсэн тухай актад шатахуун тээврийн уг хоёр чиргүүл хавидалдан гал гарч улмаар дэлбэрч болох бодит аюултай гэжээ. Иймээс давхар ёроолтой сав бүхий нефть тээгч онгоцоор л (танкер) уг ажлыг гүйцэтгэдэг. Ердөө 0.04 мм зузаан, ганц дан, олон нөхөөс тавьсан ёроолтой “Ургац” чиргүүл “Сүхбаатар” онгоцтой хавирадаж, аль эсвэл хад чулуу, зогсоол мөргөөд галын аюул гаргадаггүй юм гэхэд тээж яваа 300 тонн нефтиэ нуурт юулчихийг үгүй гэх

арга алга. Зогсоолдоо байсан бүхэл бүтэн хөлөг онгоцыг нуурт живүүлчхээд одоо зөвхөн бөөр нь харлаж байгаатай адил нэг л өдөр Хөвсгөл нуурын ус тэр аяараа нефтийн бүрхүүлтэй болж амьтай бүхэн нь сөнөж уставал хариуцах эзэн нь хэн бэ? Ийм асуултыг Тээврийн яамны сайд Д.Ёндонсүрэнд тавилаа.

Сайд түүний нэгдүгээр орлогч, бусад хүн оролцсон ярианаас “Ургац” чиргүүлийг танкераар сольж, эсвэл нуураар нефть тээхээ бүр болиулах арга хэмжээг ойрын таван жилд авахгүй, бүр ядахдаа чиргүүлийг эрэг дээр татаж гарган их засвар хийх техник хэрэгсэл ч байхгүй учир үе үе нөхөж цойлдооос өөр хүч, бололцоо уг яаманд алга гэсэн дүгнэлт хийлээ.

Хүч бололцоогоор ядмагдан суусаар байх хооронд Хөвсгөлийн цэнгэг ус, амьд ертөнцийнх нь талаар зөвхөн гашуун дурсамжаас өөр юм үлдэхгүй сөрөг арга хэмжээг ашиглах хугацаа нь аль хэдийнээ дууссан “Ургац” чиргүүл өрсөөд авчихвал хэчнээн харамсаад ч нөхөшгүй гарз болно. Хөвсгөлтэй бас дахин арван жилийн турш галаар тоглох Тээврийн яамны эрмэлзлийг эрс шууд тас цохих эрх мэдэл бүхий өөр байгууллага үнэхээр алга гэж үү?

Цэрэндоржийн Балдорж

Даалгавар 1. Эхийг бүтцээр нь зөв зааглан ялгаж, хэсэг бүрд өгүүлэгдэж буй агуулгаар нэр өгөөрэй. (2 оноо)

Эхлэл хэсэг:

Гол хэсэг:

Төгсгөл хэсэг:

Даалгавар 2. Эхээс нийгмийн болон соёлын хам сэдвийн жишээ нэг нэгийг олж бичээрэй. (2 оноо)

Нийгмийн хам сэдэв:

Соёлын хам сэдэв:

Даалгавар 3. Эхэд ямар асуудлыг гол болгон хөндсөн байна вэ? Тэрхүү асуудлаа чухал гэдгийг ямар баримтуудаар баталсан байна вэ? (3 оноо)

Асуудал

Баримт

Даалгаар 4. Эхээс гол санааг илэрхийлж буй өгүүлбэрийг олж бичээд, яагаад гол санаа гэж бодож буйгаа батлан тайлбарлаарай. (3 оноо)

Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэр:

Тайлбар:

Даалгаар 5. Эхэд зохиолч “Далай ээжээ хөнөөхөөр цаазын тавцан бэлтгэж байна” гэжээ. Хэрэв чи зохиогчоос эсрэг үзэл бодолтой байвал түүнийгээ ямар баримт ашиглан илэрхийлэх вэ? Чиний сонгосон баримтад хүн итгэж, чамтай санал нэгдэхээр байх хоёр баримтыг бичээрэй. (3 оноо)

Баримт 1:

Баримт 2:

Даалгавар 6. “гараа угаах” гэсэн хэлц үгийг ашиглан дэлгэрэнгүй өгүүлбэр бичээрэй. Чиний бичсэн өгүүлбэр утга, бүтэц, найруулгын алдаагүй, хэлц үгийн утгыг хам орчноос ойлгож болохор байхыг анхаарна уу. (2 оноо)

Даалгавар 7. Сурах бичгээс авсан эхийн хэсгийг үндэсний бичгээр бичээрэй. (5 оноо)

Монгол ардын үгэнд өсөх малын зүс нэг гэдэг бөгөөд үүнээс үндэслэж малаа зүс нийлүүлэх гэдэг тусгай ухамсарт үйл ажиллагаа байж, түүнийг сонгон үргүүлэхэд чухалчлан анхаардаг байдал бэлхэн харагддаг. Үүний дүнд зуны аагим халуун, ган гачиг, өвлийн хүйтэн, цас зудыг давах нь малын зүстэй холбоотой байдаг. (Сурах бичиг 45-р тал)

Даалгавар 8. Нийгэмд дохио өгөх зорилгоор “Хамт олноороо нэгдье” сэдвээр сургуулийн орчинд үүсдэг бэрхшээлтэй асуудлыг сурагчид оролцоо, санаачилгаараа яж зөв зохистой шийдэж болох санал дэвшүүлсэн эсээ бичээрэй.

Бичихдээ: Эхийн бүтэц, өнгө аяс, сэдэв, агуулгын харьцааг оновчтой гаргаж, дүр дүрслэл, баримт мэдээллийг зохистой ашиглан, гаргацтай, найруулга, зөв бичих дүрмийн алдаагүй, 250-280 үгэнд багтаан, хөх өнгийн балаар бичихийг анхаар. (20 оноо)

Үгийн тоо (.....)

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

Засагч багш нарт:

Шалгалтын материалыг засаж оноожулахаас өмнө засалт хийх багш нар бүгд материалыг уншиж, оноо өгөх нэгдсэн нэг ойлголттой болно.

Боломжтой бол засагч багш нар ажлаа хуваарилахдаа материалын тоог тэнцүүлж, таван багшид дөч дөчин материал гэх биш, бүх шалгуулагчийн 1-3-р даалгаврыг нэг багш, 4-7- даалгаврыг нэг багш, 8-р даалгаврыг гурван багш гэх мэтээр хуваарилах. Энэ нь шалгалтын дүн үнэн зөв, шударга, бодитой байхад эерэг нөлөөтэй.

Шалгалтыг зөвхөн 0, 1, 2, 3 гэх мэт бүхэл оноогоор дүгнэнэ. 0.5, 1.5, 2.5 гэх мэт бутархай оноог ямар ч тохиолдолд өгөхгүй.

Оноо өгөх зарчим:

Даалгавар 1. Нийт 2 оноо

Эхийн бүтцийг зөв зааглан агуулгыг хангахуйц нэрлэсэн бол 2оноо

Эхийн бүтцийн аль нэг хэсгийг буруу заагласан эсвэл аль нэг хэсэгт оноосон нэр тохиромжгүй бол 1 оноо

Эхийн бүтцийг бүхэлд нь буруу заагласан, хэсгүүдэд оноосон нэршил тохиромжгүй эсвэл даалгаврыг гүйцэтгээгүй бол 0 оноо

Даалгавар 2. Нийт 2 оноо

Нийгмийн болон соёлын хам сэдвээс нэг нэг жишээ татан бичсэн бол 2 оноо

Нийгмийн болон соёлын хам сэдвээс аль нэгийг нь бичсэн эсвэл хоёул нэг хам сэдвийг илтгэж байвал 1 оноо

Сонгосон хэсэг нь хам сэдэв илтгэхгүй, хамааралгүй зүйл байх эсвэл даалгаврыг гүйцэтгээгүй бол 0 оноо

Даалгавар 3. Нийт 3 оноо

Эхэд гол болгон дэвшүүлсэн асуудлыг олсон бол 1 оноо

Эхэд дэвшүүлсэн асуудлыг зөв олоогүй бол 0 оноо

Асуудлыг тодруулахад чухал үүрэгтэй буюу санаагаа баталсан баримт 2 ба түүнээс дээш олж бичсэн бол 2 оноо /баримтууд гэж олон тоо заасан байгааг сурагч анзааран бичсэн байх ёстой/ Асуудлыг тодруулахад чухал үүрэгтэй буюу санаагаа баталсан баримт нэгийг олж бичсэн бол 1 оноо

Олж бичсэн баримт нь санааг дэмжээгүй, утга, агуулгын зөрөөтэй бол 0 оноо

Даалгавар 4. Нийт 3 оноо

Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олсон бол 2 оноо

Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олсон боловч, өөр өгүүлбэр хамт бичсэн эсвэл цогцолбороор нь авсан бол 1 оноо

Эхийн гол санааг илэрхийлэх өгүүлбэрийг олж чадаагүй бол 0 оноо

Өөрийн үгээр зөв тайлбарласан бол 1 оноо

Гол санааг буруу тайлбарласан эсвэл сонгосон өгүүлбэртэй хамааралгүй зүйлс бичсэн бол 0 оноо

Даалгавар 5. Нийт 3 оноо

Сонгосон баримт нь (1) зохиогчийн үзэл бодлын эсрэг байр сууринаас хандсан, (2) шинжлэх ухааны үндэслэлтэй, тодорхой эх сурвалжтай, (3) үнэн зөв, ёс зүйн болон оюуны өмчийн зөрчилгүй бол 3 оноо. (1), (2), (3)-ыг тус бүр 1 оноогоор дүгнэж, аль нэгийг хангаагүй тохиолдолд оноог хасна. Мөн нэг баримт дутуу бичсэн бол 1 оноо хасна.

Даалгавар 6. Нийт 2 оноо

Хэлцийг дэлгэрүүлсэн өгүүлбэр зөв бүтэцтэй, найруулгын ямар ч алдаагүй бол 1 оноо

Өгүүлбэрт бүтэц найруулгын алдаа гарсан бол 0 оноо

Хэлц өгүүлбэрийг “гэ-, хэмээ-” холбох үг ашиглан дэлгэрүүлсэн бол 1 оноо

XII ангийн агуулгаар үзэж судалсан “гэ-, хэмээ-” холбох үгсийг ашиглаагүй бол 0 оноо

Даалгавар 7. Нийт 5 оноо

0-1 алдаатай хөрвүүлсэн бол 5 оноо

2-3 алдаатай хөрвүүлсэн бол 4 оноо

4-5 алдаатай хөрвүүлсэн бол 3 оноо

6-7 алдаатай хөрвүүлсэн бол 2 оноо

8-9 алдаатай хөрвүүлсэн бол 1 оноо

10 ба түүнээс дээш үг алдаатай хөрвүүлсэн бол 0 оноо

Даалгавар 8. Нийт 20 оноо

агуулга	оноо өгөх заавар	оноо
Сэдэв ба зорилго	Зорилго хангаж бодит шийдэл санал болгож, учир шалтгааны уялдаа холбоотой сайтай бичсэн бол	5
	Учир шалтгааны уялдаа холбоо бага зэрэг алдагдсан бол	4
	Учир шалтгааны уялдаа холбоо муутай ч нэгэн сэдвээр бичсэн бол	3
	Сөрөг хандлагатай эсвэл хэд хэдэн асуудлыг хөндсөн бол	2
	Ямар нэгэн зохиол бүтээлээс санаа авсан, санааг давтсан бол	1
	Сэдэв, зорилгоос хазайсан, хуулсан бол	0
	хийгээгүй бол	X
Эшлэл баримт	Эшлэл, баримтыг оновчтой ашигласан бол	2
	Тохиромжгүй ч эшлэл, баримттай бол	1
	Эшлэл, баримтгүй бол	0
	хийгээгүй бол	X
Бичлэгийн хэлбэр тэрэл	Тодорхой хэрэгжүүлж болохуйц бодитой шийдлийг санал болгож байгаа бол	2
	Тодорхой шийдэл санал болгосон ч бодитоор хэрэгжих боломжгүй бол	1
	Ямар нэгэн бодит шийдэл санал болгоогүй, шүүмжийн шинжтэй бол	0
	хийгээгүй бол	X
Бүтэц	Эхийн бүтэц ойлгомжтой, догол мөр, зайгаар заагласан бол	3
	Эхийн бүтэц ойлгомжтой хэдий ч догол мөр зайгаар зааглаагүй бол	2
	Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийн аль нэг нь дутуу бол	1
	Эхийн бүтэц тодорхой зааггүй, санаа бүрэн биш бол	0
	хийгээгүй бол	X
Хэл зүй, найруулга	Хэл зүй найруулгын алдаагүй	3
	Хэл зүй найруулгын багахан алдаатай ч ерөнхий цогцолбор болоод бичвэрийнхээ найруулгад нөлөөлөөгүй бол	2
	Хэл зүй найруулгын алдаа нь тухайн цогцолбор болоод бичвэрийнхээ найруулгыг сулруулсан бол	1
	Хэл зүй найруулгын алдаа их бол /4+ алдаа/	0
	хийгээгүй бол	X
Үгийн тоо	250-280 хооронд бол	1
	Үгийн тоо их, бага бол	0
	хийгээгүй бол	X
Зөв бичгийн дүрэм	0-1 алдсан бол	3
	2-5 алдсан бол	2
	6-9 алдсан бол	1
	10+ бол	0
	хийгээгүй бол	X
Бичгийн соёл	Уншиж ойлгоход саадгүй бол /дармал байж болно/	1
	Уншиж ойлгоход хэцүү, үсэг, тэмдэг хооронд ялгаагүй бичсэн бол.	0
	хийгээгүй бол	X